

ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэхүү зааврыг улирлын шалгалтын материал боловсруулахад хэрэглэх бөгөөд хичээл, сургалтын үр дүн, сургалтын амжилтыг үнэлэх, хянах, оюутны суралцахуйн, багшийн багшлахуйн үйлийн чанарыг хэмжихэд ашиглана.
2. Улирлын шалгалтын материал нь тухайн хичээлээр оюутны зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, үр чадварыг олон янзаар, иж бүрэн хэмжих, үнэлэхэд чиглэсэн байна.
3. Улирлын шалгалтын материалын агуулга нь тухай хичээлийн хөтөлбөрийн агуулга, сэдвийн хүрээнд боловсруулагдсан байна.
4. Улирлын шалгалт авах үндсэн хэлбэр нь сорил /тест/ байх бөгөөд бусад шаардлагатай арга, хэлбэрээр шалгалт авахыг зөвшөөрнө.

хоёр. Шалгалтын материалд тавигдах шаардлага

5. Улирлын шалгалтын материал нь тухайн хичээлээр оюутны зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, үр чадварыг үнэн зөв, бодитой үнэлж, дүгнэхүйц, тохирол нийцэл хангагдсан, мэдлэгийг хэрэглэх түвшинд байвал зохино.
6. Улирлын шалгалтын материал нь оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг хэмжихийн зэрэгцээ мэдлэгээ сэргээн санах, баталгаажуулах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, сэтгэн бодох, тунгаан шийдэх практик ач холбогдол, бодит гүйцэтгэлд чиглэсэн байна.
7. Улирлын шалгалтын асуулт, хариулт, даалгавар нь шинжлэх ухаан үндэслэлтэй, оюутны эзэмшсэн мэдлэг, үр чадварыг нарийн тодорхой сорьсон, оновчтой, хоёрдмол утга, агуулгагүй, хоорондоо давхцаагүй, хэт урт биш, үнэн зөв байна.
8. Улирлын шалгалтын материалыг тухайн хичээлийн агуулга, сэдвийг бүрэн, жигд хамарсан байхаар боловсруулна.
9. Үндсэн болон цагийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутныг шалгах материал нэг хичээлийн хувьд ижил байна.

гурав. Багшийн эрх, үүрэг, хариуцлага

10. Улирлын шалгалтын материалыг хичээл тус бүрээр боловсруулах, түрших, тогтмол сайжруулан баяжуулж байх үүргийг хичээл заасан багш, мэргэжлийн тэнхим хариуцна.
11. Улирлын шалгалтын материал хэл бичгийн дүрмийн алдаагүй, ойлгомжтой, тодорхой, өгүүлбэрийн найруулга зүй оновчтой, логик зөрчилгүй байна.
12. Улирлын шалгалтын материалыг microsoft word програм дээр Arial фонтоор, 11pt үсгийн хэмжээтэй бичиж бэлтгэсэн байна. (жишиг загварыг үз)
13. Улирлын шалгалтын материалыг оюутнуудаар бэлтгүүлэх, засуулах, оюутнуудад урьдчилан өгөхийг хориглоно.
14. Багш тухайн хичээлийн улирлын шалгалтын тестийг түлхүүрийг хамт Сургалтын албанд улирлын шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх үүрэгтэй.
15. Тухайн хичээлийн улирлын шалгалтыг тестийн бус хэлбэрээр авдаг бол шалгалт авах хэлбэр, агуулгын тухай мэдээлэл, шалгалт авах материалыг Сургалтын албанд улирлын шалгалт эхлэхээс 7 хоногийн өмнө танилцуулж, хүлээлгэн өгөх үүрэгтэй.
16. Багш тухайн хичээлийн улирлын шалгалтын тестийг боловсруулахдаа дараах шаардлага, жишиг, харьцаанд нийцүүлсэн байна.
 - 16.1.Тестийн нийт асуулт, даалгаврын тоо: 100-120
 - 16.2.Тестийн нийт асуулт, даалгаврын 50% нь хөнгөн /50-60 тест/, 30% нь хүндэвтэр /30-36 тест/, 20% гүнзгий /20-24 тест/ байхаар зохиогдсон байна.
 - 16.3.Жишээ (кейс) болон туршлага (туршилт)-ын үр дүнг оруулсан байх.
 - 16.4.Нэг асуулт, даалгаврын хариултын тоо: 3 /2 хариулттай байхыг зөвшөөрөх бөгөөд нийт тестийн 20% хүртэл байна/
 - 16.5.Нэг асуулт, даалгаврын зөв хариултын тоо: 1

- 16.6. Үгүйсгэх асуултаас зайлсхийх: Эдгээрт аль нь хамаарахгүй вэ гэж асуух бол, эдгээрт алианаас бусад нь хамаарах вэ? гэх байдлаар боловсруулах
 - 16.7. Хариултууд нь утга, өгүүлбэрзүйн хувьд асуулттайгаа уялдаатай байх
 - 16.8. Хамгийн зөвийг сонгох хэлбэрээр асуулт боловсруулж буй тохиолдолд буруу хариулт гэж байхгүй байх, хамгийн зөвийг сонгох нөхцлийг хангах.
 - 16.9. Тестийн нийт асуулт, даалгаврын хариултад тоо, он, сар, өдөр, хүний нэр орсон байх хязгаар: 20% хүртэл
 - 16.10. Хоёр хариулттай тестийн хариуг “үнэн худал”, “зөв буруу”, “тийм үгүй” гэх мэт хэлбэрүүдээс оновчтой сонгож хэрэглэсэн байна.
 - 16.11. Оновчгүй, тодорхой бус хариулт үл сонгох: “мэдэхгүй”, “магадгүй”, “ихэнхдээ”, “хааяа” гэх мэт.
 - 16.12. Тестийн дэс дугаарыг автоматаар /numbering/ өгөх буюу алдаагүй бичнэ.
 - 16.13. Тестээ сайтар хянах, нягтлах, баталгаажуулах.
17. Улирлын шалгалтын материалын агуулга, зохиомж, асуулт, хариулт, даалгаврын үнэн зөв эсэх, шалгалтын материалыг нууцлал, хадгалалт, хамгаалалт, энэхүү зааварт нийцсэн байдал зэргийг тухайн багш хариуцна.

дөрөв. Сургалтын албаны эрх, үүрэг, хариуцлага

18. Улирлын шалгалтын материалыг энэхүү зааварт нийцэж буй эсэхийг хянах, шаардлага хангаагүй материалыг тухайн багшид /тэнхимд/ буцаах эрхтэй.
19. Улирлын шалгалтын материалыг зохих хугацаанд хүлээн авах, нууцлалыг хангах үүрэгтэй.
20. Улирлын шалгалт авах тестийг тухайн хичээлийн тестийн сангаас санамсаргүй түүврээр, шалгалт эхлэхээс 10-12 цагийн өмнө E-Uni програмд байршуулах ба дараах шаардлагыг хангасан байна.
 - 20.1. Тестийн шалгалтын хувилбар: 1
 - 20.2. Тестийн нийт асуулт, даалгаврын тоо: 60
 - 20.3. Тестийн шалгалтын үргэлжлэх хугацаа: 60 минут
 - 20.4. Хөнгөн хэлбэрийн асуултын зөв хариулт бүрийн оноо: ~0,2 оноо
 - 20.5. Хүндэвтэр хэлбэрийн асуултын зөв хариулт бүрийн оноо: ~0,6 оноо
 - 20.6. Гүнзгий /хүнд/ хэлбэрийн асуултын зөв хариулт бүрийн оноо: ~1,1 оноо
 - 20.7. Тестийн зөв хариултын нийлбэр дээд оноо: 30
 - 20.8. Тестийн нийт асуулт, даалгаврын 50% нь хөнгөн /30 тест/, 30% нь хүндэвтэр /18 тест/, 20% гүнзгий /12 тест/ байна.

тав. Бусад зүйл

21. Энэхүү зааврыг нь улирлын шалгалтаас бусад түвшиний шалгалтын материал боловсруулахад хэрэглэж болно.
22. Улирлын шалгалтын материалыг хамтарч, багаараа боловсруулж болно.
23. Улирлын шалгалтын материалыг тэнхимийн эрхлэгч хянах эрхтэй.
24. Энэхүү зааврыг баримтлаагүйгээс зөрчил үүсэх, оюутан хохирсон тохиолдолд холбогдох багш, алба, нэгж хариуцлага хүлээнэ.

“.....” ХИЧЭЭЛИЙН

УЛИРЛЫН ШАЛГАЛТЫН ТЕСТ

/2023-2024 оны хичээлийн жилийн II улирал/

Хөнгөн тест /зөв хариултыг шар өнгөөр тэмдэглэв/

1. Энэ үнэлгээ нь суралцагчдын ахиц амжилтыг тодорхойлж байдаг. Хэрэв ахиц гарахгүй байвал бэрхшээл байгааг харуулж байгаа хэрэг юм. Энэ нь ямар үнэлгээ вэ?

A. Түвшин тогтоох үнэлгээ

B. Оношлох үнэлгээ

C. Явцын үнэлгээ

2. Энэ үнэлгээг сургалт эхлэхийн өмнө өгдөг ба аливаа сургалтын өмнө суралцагчдын эзэмшсэн суурь мэдлэг, чадварын түвшинг тодорхойлох хэрэгтэй болдог. Энэ нь ямар үнэлгээ вэ?

A. Түвшин тогтоох үнэлгээ

B. Оношлох үнэлгээ

C. Явцын үнэлгээ

3.

Хүндэвтэр тест /зөв хариултыг шар өнгөөр тэмдэглэв/

1. Боловсрол судлал юуг судалдаг вэ?

A. Боловсролын судалгааны аргуудыг

B. Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалыг

C. Хүний хөгжил төлөвшлийн холбоо хамаарлыг

2. З.Фрейдийн үзснээр зүүд бол тухайн хүний үл ухамсарлахуй руу шахагдан түрэгдсэн ханаагүй дурын болон мөрөөдлийнюм.

A. Бөөгнөрөл

B. Сэтгэц биологийн үзэгдэл

C. Бүгд

3.

Хүнд тест /зөв хариултыг шар өнгөөр тэмдэглэв/

1. Сурган хүмүүжүүлэх ухаанд хүүхдийн хөгжил төлөвшлийг дараах ерөнхий чиглэлээр задлан авч үздэг.

A. Бие бялдар, Оюун ухаан, Ёс суртахуун, Хөдөлмөр

B. Бие бялдар, Оюун ухаан, Хөдөлмөр

C. Оюун ухаан, Ёс суртахуун, Хөдөлмөр, Мэдлэг

2. Эдгэшгүй хийгээд эмчлэгдэхгүй, бас үхэлд хүргэх аюултай хүнд өвчин тусахад өвчтөний түүнд үзүүлэх сэтгэл зүйн хариу урвалыг зөв дараалалд оруулна уу.

1. Шокд орох ба өвчнөө үгүйсгэх

2. Өвчнөө хүлээн зөвшөөрөх ба эвлэрэх

3. Дасан зохицох ба хямрах

4. Бухимдах

A. 1, 2, 3, 4

B. 4, 1, 3, 2

C. 1, 4, 2, 3

3.